



**БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗАР**
Гүйцэтгэлийн аудитын тайлан

**ТӨСВИЙН ХӨРӨНГИЙН БҮРДҮҮЛЭЛТ,
ЗАРЦУУЛАЛТ, ШҮҮХИЙН ШИЙДВЭР
ГҮЙЦЭТГЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА ҮР ДҮНТЭЙ
ХЭРЭГЖСЭН БАЙНА.**

2020 оны 11 дүгээр сар

**АУДИТЫН СЭДЭВ: Аймгийн Шүүхийн
шийдвэр гүйцэтгэх газрын үйл ажиллагааны
үр дүн**

2020 он

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар	3
Хүснэгтийн товъёг	4
Хавсралтын товъёг	4
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл	5-6
БҮЛЭГ 1. ТӨСВИЙН ХӨРӨНГИЙН БҮРДҮҮЛЭЛТ, ЗАРЦУУЛАЛТ ҮР АШИГТАЙ БАЙНА.	7
1.1. Санхүүжилт, орлогын эх үүсвэрийг үндэслэлтэй төлөвлөж, төсвийг зориулалтын дагуу зарцуулсан байна.	7
1.1.1. Байгууллагын төсвийн төлөвлөлтөйг үндэслэлтэй хийсэн байна....	7-8
1.1.2. Төсвийн орлого, зардлыг зохих журмын дагуу хөтөлж ирсэн хэдий ч анхан шатны баримтын бүрдэлт хангалтгүй байна.....	8-9
1.2. Төсвийг зориулалтын дагуу зарцуулсан байна.....	9
1.2.1 Батлагдсан бүтэц, орон тооны жишгийг мөрдөж ажилласан байна.....	9
1.2.2. Цалингийн зардлыг зориулалтын дагуу зарцуулсан байна.....	9-10
1.2.3. Бараа үйлчилгээний бусад зардлыг батлагдсан төсвийн хүрээнд зарцуулсан байна.	10-11
1.2.4. Худалдан авах ажиллагааг 2019 оноос хэрэгжүүлж эхэлсэн байна.....	11
1.3. Байгууллагын дотоодын хяналт үр нөлөөгүй байна.	11
1.3.1. Байгууллагын дотоод хяналт, түүний үр дүн хангалтгүй байна.....	11-12
1.3.2. Өмч, хөрөнгийн ашиглалт, зарцуулалтад бүртгэлээр тавих хяналтыг зохих түвшинд хэрэгжүүлсэн байна.	12-13
1.3.3. Шилэн дансны зарим мэдээллийг 2017, 2018 онд бүрэн оруулаагүй байна.	13
БҮЛЭГ 2. ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЭРЭГЖИЛТ ҮР ДҮНТЭЙ БАЙНА.....	14
2.1. Захиргааны хэргийн шийдвэр гүйцэтгэх үйл ажиллагааны хэрэгжилт үр дүнтэй байна.....	14
2.1.1. Шийдвэр гүйцэтгэх үйл ажиллагааны бүртгэл, тайлагналыг зохих журмаар хийсэн байна.	14
2.1.2. Төрийн албанаас үндэслэлгүй халагдсан хүмүүсийн хохирлыг барагдуулах ажлын хэрэгжилт үр дүнтэй байна.	14-15
2.1.3. Шүүхийн шийдвэрийн төлбөрийн орлого, зарлагыг зохих журмаар бүртгэж, тайлагнасан байна.....	15-17
2.1.4 Шийдвэр гүйцэтгэгч нарт олгох мөнгөн урамшууллыг зохих журмаар олгосон байна.....	17
2.2. Хураагдсан хөрөнгийн дуудлага худалдааг холбогдох хуулийн дагуу зохион байгуулжээ.....	17
2.2.1. Хураагдсан хөрөнгийн нэгдсэн бүртгэл, тайлан хийгдээгүй байна.....	17
2.2.2. Дуудлага худалдааг зохих журмын дагуу зохион байгуулсан байна.	17-18
2.2.3. Дуудлага худалдааны төлбөрийн орлогыг төлбөр авагчид шилжүүлсэн байна.	18
Холбогдох байгууллагын санал:	19
Саналд өгсөн тайлбар:	20
ДҮГНЭЛТ:	21
ЗӨВЛӨМЖ:.....	22
ХАВСРАЛТУУД:.....	23-28

Товчилсон үгийн тайлбар

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ШШГЕГ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ШШГГ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар
ШГ	Шүүхийн гүйцэтгэх

Хүснэгтийн товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	ШШГГ-ын 2017-2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	8
Хүснэгт 2	ШШГГ-ын 2017-2019 оны санхүүгийн тайлан	9
Хүснэгт 3	ШШГГ-ын 2017-2019 оны Төрийн банкны хуулга, санхүүгийн баримт	17-18
Хүснэгт 4	ШШГГ-ын 2017-2019 оны Төрийн банкны хуулга, санхүүгийн баримт	18

Хавсралтын товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хавсралт 1	2017 онд Төрийн албанаас үндэслэлгүй халагдсан ажилтанд шүүхийн шийдвэрээр олгосон нөхөн төлбөрийн судалгаа	24
Хавсралт 2	2018 онд Төрийн албанаас үндэслэлгүй халагдсан ажилтанд шүүхийн шийдвэрээр олгосон нөхөн төлбөрийн судалгаа	25-26
Хавсралт 3	2019 онд Төрийн албанаас үндэслэлгүй халагдсан ажилтанд шүүхийн шийдвэрээр олгосон нөхөн төлбөрийн судалгаа	27
Хавсралт 4	2020 онд Төрийн албанаас үндэслэлгүй халагдсан ажилтанд шүүхийн шийдвэрээр олгосон нөхөн төлбөрийн судалгаа	28
Хавсралт 5,6,7	2017-2019 оны төсвийн гүйцэтгэлтэй холбоотой судалгаа	30

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл Монгол Улсын Ерөнхий аудиторын "Аудитын төлөвлөгөө шинэчлэн батлах тухай" 2020 оны А/53 дугаар тушаал, аймаг дахь Төрийн аудитын газрын 2020 онд хийх аудитын төлөвлөгөөний дагуу "Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын үйл ажиллагааны үр дүн"-д Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3-т заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийнэ.
Аудитын зорилт	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2017-2019 оны үйл ажиллагааг дараах чиглэлээр шалгаж, дүгнэлт гаргах, үр ашгийг дээшлүүлэх санал зөвлөмж боловсруулан холбогдох байгууллага албан тушаалтанд хүргүүлэх, аудитын дүнг олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэв. Дээрх зорилтын хүрээнд дараах чиглэлийн дагуу аудитыг гүйцэтгэнэ. Үүнд: ➤ Төсвийн хөрөнгийн төлөвлөлт, зарцуулалт үр ашигтай байна уу? ➤ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх үйл ажиллагааны хэрэгжилт үр дүнтэй байна уу?
Аудитын хамарсан хүрээ	Аудитад аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2017, 2018, 2019 оны үйл ажиллагаа, төсвийн гүйцэтгэл, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг бүрэн хамруулж, ажлын тайлан болон санхүүгийн тайлан, баримт материалд үндэслэн, бодит байдлыг үндэслэн шалгав.
Аудитын хязгаарлалт	
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	Аудитыг гүйцэтгэхдээ АДБОУС 3000-3100, Монгол Улсын Төрийн аудитын стандарт-Гүйцэтгэлийн аудит MNS 6817:7-2020, гүйцэтгэлийн болон санхүүгийн тайлангийн аудитын арга зүйг ашиглан Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн газрын төсвийн төлөвлөлт, зарцуулалт, шүүхийн шийдвэр гүйцэтгэх үйл ажиллагааны хэрэгжилт үр дүнгийн талаар холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга, лавлагаа авах, баримт материалыг шалгах, давтан тооцоолох, харьцуулах, дүн шинжилгээ хийн аудитын хөтөлбөр, арга зүйн дагуу дагуу нотлох зүйл цуглуулж, дүгнэлт зөвлөмж боловсруулна.

**Аудитын
бүрэлдэхүүн,
хугацаа**

Аудитыг аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд тэргүүлэх аудитор М.Хуанган хянан удирдаж, аудитын менежер Х.Женисбек чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор М.Айнур, аудитор Б.Үүрийнтуяа нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хамтран гүйцэтгэв.

Хүндрэл бэрхшээл

.....

БҮЛЭГ 1.ТӨСВИЙН ХӨРӨНГИЙН БҮРДҮҮЛЭЛТ, ЗАРЦУУЛАЛТ ҮР АШИГТАЙ БАЙНА.

1.1. Санхүүжилт, орлогын эх үүсвэрийг үндэслэлтэй төлөвлөж, төсвийг зориулалтын дагуу зарцуулсан байна.

1.1.1. Байгууллагын төсвийн төлөвлөлтийг үндэслэлтэй хийсэн байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2017-2019 онуудын батлагдсан төсвийг харьцуулж судалгаа хийж үзэхэд төсвийн төлөвлөлт дараах байдалтай байна.Үүнд:

Хүснэгт №01

Үзүүлэлт	2017 он	2018 он	2019 он	2017-2018		2018-2019	
	Батлагдсан төлөвлөгөө	Батлагдсан төлөвлөгөө	Батлагдсан төлөвлөгөө	зөрүү өсөлт	өсөлтийн хувь	зөрүү өсөлт	өсөлтийн хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	460 744,10	482 843,30	537 791,00	22 099,20	104,80	54 947,70	111,38
УРСГАЛ ЗАРДАЛ	460 744,10	481 612,90	537 791,00	20 868,80	104,53	56 178,10	111,66
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	450 094,10	481 612,90	536 621,40	31 518,80	107,00	55 008,50	111,42
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	331 257,00	351 924,20	398 120,30	20 667,20	106,24	46 196,10	113,13
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	11 278,00	7 684,00	8 255,00	- 3 594,00	68,13	571,00	107,43
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БУСАД ЗАРДАЛ	107 559,1	122 004,7	130 246,1	14 445,6	113,4	8241,4	106,7
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	10 650,00	1 230,40	1 169,60	- 9 419,60	11,55	- 60,80	95,06
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	460 744,10	482 843,30	537 791,00	22 099,20	104,80	54 947,70	111,38
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	450 744,10	482 693,30	537 641,00	31 949,20	107,09	54 947,70	111,38
Улсын төсвөөс санхүүжих	450 744,10	482 693,30	537 641,00	31 949,20	107,09	54 947,70	111,38
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	10 000,00	150,00	150,00	- 9 850,00	1,50	-	100,00
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	10 000,00				-	-	
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		150,00	150,00	150,00	-	-	100,00

Эх сурвалж: ШШГГ-ын 2017-2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2017 оны үйл ажиллагаанд нийт 460.7 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 450.1 сая төгрөгийг бараа үйлчилгээний зардалд, 10.6 сая төгрөгийг урсгал шилжүүлэгт зарцуулахаар батлагдаж, нийт зардлын 450.7 сая төгрөгийг улсын төсвөөс, 10.0 сая төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2018 оны үйл ажиллагаанд нийт 482.8 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 481.6 сая төгрөгийг бараа үйлчилгээний зардалд, 1.2 сая төгрөгийг урсгал шилжүүлэгт зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 482.7 сая төгрөгийг улсын төсвөөс, 0.1 сая төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2019 оны үйл ажиллагаанд нийт 537.8 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 536.6 сая төгрөгийг бараа үйлчилгээний зардалд, 1.2 сая төгрөгийг урсгал шилжүүлэгт зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 537.6 сая төгрөгийг улсын төсвөөс, 0.1 сая төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

3 жилийн батлагдсан төсвийг харьцуулж үзэхэд 2017-2018 онд батлагдсан төсөв нь 1.4 хувиар буюу 22.1 сая төгрөгөөр нэмэгдсэн ба цалингийн зардал 17.1 сая төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардал 5.0 сая төгрөгөөр нэмэгджээ.

2018-2019 онд батлагдсан төсөв 54.9 сая төгрөг буюу 11.4 хувиар нэмэгдсэнээс цалингийн зардал 46.7 сая төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардал 8.2 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

2017-2019 оны төсвийн өсөлтийн дийлэнх хувийг цалингийн зардлын өсөлт эзэлж байгаа нь Засгийн газраас төрийн албан хаагчдын цалинг нэмэгдүүлсэнтэй холбоотой болон цалингийн шатлал, нэмэгдлийн өөрчлөлттэй холбоотой байна.

Тус газар нь төсвийн хэмнэлтээс 2017 онд 2.4 сая төгрөгийг, 2018 онд 4.5 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлжээ. 2017-2019 онуудын авлага, өглөгийн судалгаа дараах байдалтай байна. Үүнд:

Хүснэгт №02

онууд	2017		2018		2019	
	авлага	өглөг	авлага	өглөг	авлага	өглөг
үлдэгдэл	-	183.6	83.9	8.9	-	-

Эх сурвалж: 2017-2019 оны санхүүгийн тайлан

Жилийн эцсийн тооцоогоор 2017 оны эцэст 0.2 сая төгрөгийн, 2018 оны эцэст 0.01 сая төгрөгийн өглөгтэй, 2018 оны эцэст 0.1 сая төгрөгийн авлагатай гарсан байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын сүүлийн 3 жилийн төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл өр, авлагын мэдээг харьцуулж үзэхэд цалингийн болон бусад зардлын өсөлтийг тухай бүр төлөвлөж ажиллаж төсвийг үндэслэлтэй төлөвлөсөн байна.

1.1.2. Төсвийн орлого, зардлыг зохих журмын дагуу хөтөлж ирсэн хэдий ч анхан шатны баримтын бүрдэлт хангалтгүй байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар нь 2017 онд төсвөөс 450.7 сая төгрөгийн санхүүжилтийг авч, туслах үйл ажиллагааны орлогоос 10.0 сая төгрөгийн орлого оруулан 458.3 сая төгрөгийг зарлага санхүүжилтээр ажиллаж, төсвөө 2.4 сая төгрөгөөр хэмнэж, төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Цалингийн зардалд 342.5 сая төгрөг, бусад бараа үйлчилгээний зардалд 118.2 сая төгрөг батлагдсанаас цалингийн зардалд 340.5 сая төгрөг, бусад бараа үйлчилгээний зардалд 117.8 мянган төгрөг зарцуулжээ.

2018 онд гүйцэтгэлээр улсын төсвөөс 482.7 сая төгрөгийн санхүүжилт хүлээн авч, туслах үйл ажиллагааны орлогоос 0.1 сая төгрөгийн орлого оруулан 478.3 сая төгрөгийг үйл ажиллагаандаа зарцуулж, төсвөө 4.5 сая төгрөгөөр хэмнэж төсөвт буцаан төвлөрүүлжээ.

Тайлант оны цалингийн зардалд 359.6 сая төгрөг, бусад бараа үйлчилгээний зардалд 123.2 сая төгрөг төлөвлөгдсөнөөс цалингийн зардалд 355.5 сая төгрөг, бусад бараа үйлчилгээний зардалд 122.8 сая төгрөг зарцуулсан байна.

Тус газар нь 2019 онд улсын төсвөөс 537.6 сая төгрөгийн санхүүжилтийг хүлээн авч, туслах үйл ажиллагааны орлогоос 0.1 сая төгрөгийн орлого оруулж, 537.8 сая төгрөгийг үйл ажиллагаандаа зарцуулж, төсөвтөө багтаан үйл ажиллагаа явуулжээ.

Цалингийн зардалд 406.4 сая төгрөг, бусад бараа үйлчилгээний зардалд 131.4 сая төгрөг батлагдсаныг бүрэн зарцуулсан байна.

2017-2019 онуудад зардлыг баталсан төсөвт багтаан зарцуулах талаар санаачилга гарган ажилласан байна.

1.2. Төсвийг зориулалтын дагуу зарцуулсан байна.

1.2.1 Батлагдсан бүтэц, орон тооны жишгийг мөрдөж ажилласан байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын 2017 оны 9 дүгээр сарын 15-ны өдрийн Б/1086 дугаар тушаалаар Баян-Өлгий аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын бүтэц орон тоог 32 хүнээр баталж ирүүлсэн байна.

Тус газар нь 2017 онд нийт 34, 2018-2019 онуудад 32 орон тоогоор үйл ажиллагаа явуулсан байна.

2018, 2019 онуудад ШШГЕГ-аас баталсан бүтэц, орон тооны жишгийг мөрдөж ажилласан байна.

1.2.2. Цалингийн зардлыг зориулалтын дагуу зарцуулсан байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2017 оны цалин, нэмэгдэл урамшуулалд 331.3 сая төгрөгийн, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардалд 11.3 сая төгрөгийн төсөв батлагдсан байна. Гүйцэтгэлээр цалингийн зардалд 329.2 сая төгрөг, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардалд 11.3 сая төгрөг зарцуулж, нийт дүнгээр 2.1 сая төгрөгөөр хэмнэсэн байна.

2018 онд цалин, нэмэгдэл урамшуулалд 351.9 сая төгрөг, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардалд 7.7 сая төгрөгийн төсөв батлагдсанаас гүйцэтгэлээр цалингийн зардалд 347.8 сая төгрөг, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардалд 7.7 сая төгрөг зарцуулж, нийт дүнгээр 4.1 сая төгрөгөөр хэмнэжээ.

2019 онд цалин болон нэмэгдэл урамшуулалд 398.1 сая төгрөг, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардалд 8.3 сая төгрөгийн төсөв батлагдсанаас төсөвтөө багтаан үйл ажиллагаа явуулсан байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар нь байгууллагын даргын тушаалаар ажиллагсдын ажилласан жил, бусад нэмэгдэл, цолны нэмэгдлийг харгалзан, Ерөнхий газраас ирүүлсэн бүтэц, орон тооны жишигтэй уялдуулан тухайн жилийн цалинг шинэчлэн тогтоох ёстой байтал 2017, 2018, 2019 онуудад ажилчдын цалинг шинэчлэн тогтоосон ямар нэгэн тушаал шийдвэр гаргаагүй байна.

Санхүүгийн Unicus программд оруулсан цалингийн мэдээллийг ашиглан 2018, 2019 онуудын цалин тогтоосон байдлыг тулгаж үзэхэд, цалингийн шатлал, нэмэгдлийг буруу тогтоосон зөрчил дутагдал илрээгүй боловч 2018 оны санхүүгийн баримтаар нийтлэг дараах зөрчлүүд илэрсэн байна.Үүнд:

- Цалингийн бодолт, гарт бэлэн олгох дүнгээр бэлтгэсэн цалин олгосон жагсаалтад гарын үсэг зуруулж, ажилчдад танилцуулаагүй,
- 7 дугаар сарын 13.8 сая төгрөгийн урьдчилгаа олгосон баримт санхүүгийн баримтад хавсаргагдаагүй,
- 10 дугаар сарын цалин бодсон хүснэгтийг санхүүгийн баримтад хавсаргаагүй,

- Сар бүрийн ажилчдын цагийн балансыг санхүүгийн баримтад огт хавсаргаагүй,
- Ажилчдад амралт олгох хуудсыг зарим саруудад дутуу хавсаргасан, амралтын цалин бодсон баримтыг санхүүгийн баримтад хавсаргаагүй, орхигдуулсан,
- 4 дүгээр сард 4 хүнд урамшуулал олгосон боловч, урамшуулал олгох тушаалыг санхүүгийн баримтад хавсаргаагүй,

Дээрх материалуудыг санхүүгийн баримтад дутуу хавсаргаснаас 2018 онд цалинг үнэн зөв бодож олгосон эсэхийг шалгах боломжгүй болсон байна. Тухайлбал: 2018 оны 3 дугаар сард 2 ажилтанд тус бүр 2 хоногийн цалинг дутуу олгосон, 4 дүгээр сард 1 ажилтанд 1 хоногийн цалинг илүү олгосон тооцоо гарсан боловч цагийн бүртгэл байхгүй тул эцэслэж тулгалт хийх боломжгүй, мөн амралт олгох хуудас, цагийн балансыг санхүүгийн баримтад хавсаргаагүйгээс 5-12 дугаар сарын ажилтны амарсан хугацаа ажилласан хугацааг тооцож, цалинг зөв бодож олгосон эсэхийг шалгах боломжгүй байна.

Аудитын дүнгээр илэрсэн зөрчил дутагдлыг арилгах, ажиллагсдын цалинг оны эхэнд шинэчлэн тогтоож байгууллагын даргын тушаалаар баталгаажуулах, цалингийн цэсийг ажилчдад сар бүр танилцуулж гарын үсэг зуруулах, цагийн баланс, амралт олгох хуудас, амралтын цалин тооцсон хүснэгт зэрэг цалин олголттой холбоотой анхан шатны баримтуудыг санхүүгийн баримтад бүрэн хавсаргаж баримтжуулах, санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоодын хяналтыг шаардлагатай түвшинд хүргэж ажиллахыг албан шаардлагаар үүрэг болголоо.

1.2.3. Бараа үйлчилгээний бусад зардлыг батлагдсан төсвийн хүрээнд зарцуулсан байна.

2017-2019 оны цалингаас бусад бараа үйлчилгээний зардлын зарцуулалтыг батлагдсан төсөвтэй зэрэгцүүлж үзэхэд дараах байдалтай байна.Үүнд:

2017 онд бусад бараа ажил үйлчилгээний зардалд 107.6 сая төгрөг, урсгал шилжүүлэгт 10.6 сая төгрөг зарцуулахаар төлөвлөснөөс гүйцэтгэлээр бусад бараа ажил үйлчилгээний зардалд 107.0 сая төгрөг зарцуулж, 0.5 сая төгрөгөөр, урсгал шилжүүлэгт 10.8 сая төгрөгийг зарцуулж, 0.2 сая төгрөгөөр хэмнэсэн байна.

Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, хангамж, бараа материалын зардал, нормативт зардал, томилолт зочны зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж зэрэг зардлыг 0.2-0.3 сая төгрөгөөр хэмнэж, бараа үйлчилгээний бусад зардлыг 0.4 сая төгрөгөөр хэтрүүлжээ.

2018 онд бусад бараа ажил үйлчилгээний зардалд 122.0 сая төгрөг, урсгал шилжүүлэгт 1.2 сая төгрөг төлөвлөгдөж, гүйцэтгэлээр бусад бараа ажил үйлчилгээний зардалд 121.6 сая төгрөг зарцуулж, 0.4 сая төгрөгөөр, урсгал шилжүүлэгт 1.1 сая төгрөг зарцуулж, 0.1 сая төгрөгөөр хэмнэсэн байна.

Бараа үйлчилгээний бусад зардлуудыг зардлын зүйл ангиар харьцуулж үзэхэд хэтрүүлэн зарцуулсан зардал байхгүй бөгөөд зардлыг нийт дүнгээр 0.3 сая төгрөг хэмнэсэн байна.

2019 онд бусад бараа ажил үйлчилгээний зардалд 130.2 сая төгрөг, урсгал шилжүүлэгт 1.2 сая төгрөг зарцуулахаар төлөвлөгдсөнөөс гүйцэтгэлээр бусад бараа ажил үйлчилгээний зардалд 130.2 сая төгрөг, урсгал шилжүүлгийн зардалд 1.2 сая төгрөгийг төсөвтөө багтаан зарцуулсан байна.

Тайлант онд бараа үйлчилгээний бусад зардлуудыг батлагдсан төсвийн хүрээнд зарцуулсан байна.

1.2.4. Худалдан авах ажиллагааг 2019 оноос хэрэгжүүлж эхэлсэн байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар нь батлагдсан төсвийн хүрээнд 2017 онд 17.4 сая төгрөгийн, 2018 онд 8.5 сая төгрөгийн, 2019 онд 9.1 сая төгрөгийн биет ба биет бус хөрөнгийг шууд гэрээгээр худалдан авсан байна.

2017, 2018 онуудад тус газраас хоолны зардлын бэлтгэн нийлүүлэгчийг сонгон шалгаруулах талаар тендер зарлаагүй байна. Орон нутгийн өмчийн газраас 2019 онд тус газрын хоолны зардлын бэлтгэн нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тендер зарлаж, “Көкжелкен” ХХКомпанийг хоолны зардлын бэлтгэн нийлүүлэгчээр сонгон шалгаруулсан байна.

“Көкжелкен” ХХКомпаниас гэрээний дагуу 2019 оны 5 дугаар сараас 8 дугаар сард нийт 12.7 сая төгрөгийн худалдан авалт хийсэн байна. Гэрээг гүйцэтгэх явцад бэлтгэн нийлүүлэгч “Көкжелкен” ХХКомпани нь барааны үнийг нэмэгдүүлсэн тул захиалагчийн зүгээс гэрээг цуцалж, хамтран ажиллахаас татгалзсан боловч Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын зүгээс гэрээг цуцлах болсон талаар ямар нэгэн бичиг баримт үйлдэгдээгүй байна.

1.3. Байгууллагын дотоодын хяналт үр нөлөөгүй байна.

1.3.1. Байгууллагын дотоод хяналт, түүний үр дүн хангалтгүй байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2015 оны А/209 тоот тушаалаар тус газрын дотоод хяналт шалгалт явуулах, хөрөнгө орлогын мэдүүлгийг бүртгэх, хянах, хүлээн авах эрх бүхий албан тушаалтнаар тасгийн дарга бөгөөд ахлах шийдвэр гүйцэтгэгчийг томилж ажиллуулахаар баталсан байна.

Тус газрын даргын 2018 оны А/05, 2019 оны А/08 тоот тушаалуудаар Дотоод хяналт шалгалт, аюулгүй байдлыг хангах ажлын төлөвлөгөө гарган батлуулж ажилласан байна. Дотоод хяналт шалгалтаар 2017, 2019 оны санхүүгийн үйл ажиллагааг хамруулан шилэн дансны хуулийн хэрэгжилтийг шалгаж, хуулийн хэрэгжилт хангалтгүй байгааг илрүүлэн нягтлан бодогчид хариуцлага тооцуулан үүрэг даалгавар өгч биелэлтийг хангуулж ажилласан байна.

Дотоод хяналт шалгалтаар 2018 онд санхүүгийн үйл ажиллагааг шалгасан гэх боловч байгууллагын ажлын тайланд шалгалт хийгдсэн талаар дурдаагүй байна. Дотоод хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу 12 дугаар сард хяналт шалгалт хийж, ажлын тайланг ШШГЕГ-ын Хяналт шалгалтын газарт хүргүүлсэн байна.

Аудитаар төсвийн зарцуулалтад тавьж буй дотоодын хяналтыг шалгаж үзэхэд төсвийн зардлын бүлэг хооронд зөвшөөрөлгүйгээр гүйлгэн зарцуулсан зөрчил дутагдал илрээгүй, төсвийн сарын хуваарьт багтаан зарцуулж ирсэн боловч төсвийн зарцуулалт, баримтын бүрдүүлэлттэй холбоотой дараах нийтлэг зөрчил дутагдлууд илэрлээ.Үүнд:

Мөнгөн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэлийг санхүүгийн баримтад хавсаргахгүй орхигдуулсан, анхан шатны баримтын бүрдүүлэлт хангалтгүй, томилолтын хуудасны тамга тэмдэг дутуу, томилолтын хуудсыг хавсаргаагүй, томилолтын бэлэн мөнгө олгох маягтад гарын үсэг зуруулж, томилолтын хоногийн тооцоо хийгээгүй, замын зардлын үндсэн баримтыг хавсаргаагүй, албан томилолтоор ажиллуулахаар дуудсан албан

бичгийг хавсаргаагүй, албан хаагчийн байрны түрээсийн төлбөрийг нэмэлт данснаас төлсөн боловч үндсэн гэрээ нь байхгүй байна.

Нярав нь бараа материалын тайланг хөтөлж, нягтлан бодогчтой тооцоо нийлдэггүй, бараа материалын сар бүрийн журналын орлого, зарлагын дүн, программ дээрх орлого, зарлагын журналын дүнгээс зөрүүтэй, ихэнх сарын бараа материалын орлого, зардлын баримт, нийлүүлэгч байгууллагын падааныг санхүүгийн баримтад дутуу хавсаргасан, шаардах хуудсыг дутуу хавсаргасан, гарын үсгийн бүрдэл дутуу, шатахууны зарцуулалтад тавих хяналтыг сулруулсан, шатахууны худалдан авалт хийсэн НӨАТ-ын баримтыг санхүүгийн баримтад дутуу хавсаргасан, шатахууны зарцуулалтын хэтрэлт хэмнэлтийн тооцоог хийгээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, “13.5-д “Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно”, 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 14 дүгээр зүйлийн 14.3-т “Нягтлан бодох бүртгэлийн мэдээлэл боловсруулах ажиллагааг дараах дарааллаар гүйцэтгэнэ”, 14.3.1-д “анхан шатны баримт бүрдүүлэх”, 14.4-т “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.1-т “аж ахуйн бүх ажил, гүйлгээ” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Аудитын дүнгээр төсвийн зарцуулалт, бүртгэл тайлагналтай холбоотой дээрх зөрчлүүдийг арилгах талаар албан шаардлага өгөгдлөө.

1.3.2. Өмч, хөрөнгийн ашиглалт, зарцуулалтад бүртгэлээр тавих хяналтыг зохих түвшинд хэрэгжүүлсэн байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын санхүүгийн алба нь ахлах нягтлан бодогч , нярав гэсэн 2 орон тоогоор ажиллажээ. Ахлах нягтлан бодогч нь касс, харилцахын хуулгыг боловсруулж, ерөнхий дэвтэр хөтлөх, байгууллагын санхүүгийн тайлан гаргах, цалин хөлс, аж ахуй, санхүүгийн албаны үйл ажиллагааг удирдан зохион байгуулж ажилласан байна. 2017 оноос 2019 оны 2 дугаар сар хүртэл ажилласан ахлах нягтлан бодогч нь ажлаас гарсан байна.

2017, 2019 оны байгууллагад хөтлөгдвөл зохих анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийг холбогдох журмын дагуу бүрэн хөтөлж, санхүүгийн баримт материалыг эмх, цэгцтэй үдэж, архивласан байна. 2018 оны санхүүгийн баримт материалыг журмын дагуу бүрдүүлээгүй, баримт материалыг эмх, цэгцтэй үдээгүй байгаа нь аудитын явцад шалгахад хүндрэлтэй байлаа.

ШШГГ-ын даргын 2017 оны А/07, 2018 оны А/02, 2019 оны А/15 дугаар тушаалуудаар өмч хөрөнгийг хамгаалах байнгын зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг баталж, зөвлөлийг 5 гишүүнтэй жил бүр шинэчлэн томилж ажиллуулсан байна.

Өмч хамгаалах байнгын зөвлөл нь “Өмч хамгаалах байнгын зөвлөл”-ийн журам, төлөвлөгөө гарган ажиллаж, газрын эзэмшилд байгаа эд хөрөнгийг худалдах, шилжүүлэх, устгах болон шинээр эд хөрөнгө олж авахтай холбогдсон харилцааг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгө олж авах, худалдах, шилжүүлэх, актлах журам болон бусад хууль, тогтоомжийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулсан байна.

Хөрөнгийн тооллогыг жил бүр хагас, бүтэн жилээр хийсэн байна. Газрын даргын 2017 оны А/85, 2018 оны А/47, 2019 оны А/56 тоот тушаалуудаар батлагдсан эд хөрөнгийн тооллогын комисс үндсэн болон эргэлтийн хөрөнгө, гүйцэтгэх хуудасны тооллогуудыг хийж үлдэгдлийг баталгаажуулжээ.

ШШГЕГ-аас 2017 онд 3.1 сая төгрөгийн байршил тогтоогч, гадна камер, принтер, 2018 онд 26.3 сая төгрөгийн Ланд круйзер-80 автомашин /бүтцийн өөрчлөлтөөр систем доторх шилжүүлгээр/, 6.6 сая төгрөгийн компьютер хэрэгсэл, 2019 онд 30.8 сая төгрөгийн Фургон автомашин, 6.6 сая төгрөгийн компьютер, бичиг баримт уншигч тоног төхөөрөмж, нийтдээ 73.4 сая төгрөгийн тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийг үнэ төлбөргүй хүлээн авсныг орлого авч данс бүртгэлд тусгасан байна.

Төсвийн хөрөнгөөр 2017 онд 10.4 сая төгрөгийн гал тогооны ком, 6.9 сая төгрөгийн хурлын ширээ, даргын өрөөний ком тавилга, 2018 онд 2.0 сая төгрөгийн цахилгаан үүсгүүр, ус шүүгч, өнгөт принтер, 2.2 сая төгрөгийн бичиг хэргийн төмөр шүүгээ, Орон нутгийн хөрөнгө оруулалтаар 4.2 сая төгрөгийн төмөр хашаа, 2019 онд 6.1 сая төгрөгийн компьютер, ноутбук, принтер, дээжийн хөргөгч, цахилгаан зуух, 2.9 сая төгрөгөөр ширээ, төмөр шүүгээ, ширээ зэрэг нийтдээ 34.7 сая төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшил худалдан авч данс бүртгэлд тусгажээ.

Тус газар нь 2017 онд 1.8 сая төгрөгийн тоног төхөөрөмж, 2018 онд 50.6 сая төгрөгийн барилга, 7.6 сая төгрөгийн тоног төхөөрөмж, 2.4 сая төгрөгийн тавилга эд хогшил, 2019 онд 52.5 сая төгрөгийн тээврийн хэрэгсэл, нийтдээ 114.9 сая төгрөгийн хөрөнгийг ТӨБЗГ-ын тогтоол, ШШГЕГ-ын даргын тоот тушаалаар акталж, данс бүртгэлээс хассан байна.

1.3.3. Шилэн дансны зарим мэдээллийг 2017, 2018 онд бүрэн оруулаагүй байна.

Тус газрын 2017-2019 оны Шилэн дансны мэдээллийг shilendans.gov.mn шалгаж үзэхэд 2017 онд 82, 2018 онд 10 мэдээлэл, 2019 онд 17 мэдээллийн хугацааг хоцроож мэдээлсэн байна.

Дээрх хугацаа хоцроосон зөрчлүүд нь шилэн дансны мэдээллийн хэсгийн Хөрөнгө оруулалт, тендер худалдан авалттай холбоотой хэсэг, Бусад хэсгүүдийн мэдээллүүдийг нөхөж тайлбаргүй оруулаагүйгээс үүдэн хугацаа хоцроосноор харагдаж байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.4, 6.3.6, 6.3.7, 6.4.3, 6.4.4, 6.4.8, 6.8.1, 6.8.2 дахь заалтууд, Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журмын холбогдох заалтуудыг хэрэгжүүлээгүй байна.

Мөн 2017 оны 2, 3, 4, 5, 6, 7, 8, 9, 11, 12 дугаар сарын, 2018 оны 1 дүгээр сар, 2019 оны 1, 2, 7 дугаар сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээ, 2017-2019 онуудын санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг хугацаа хоцроож, төсвийн хэтрэлт, хэмнэлтийн шалтгаан тайлбарыг оруулаагүй, төсвийг эдийн засгийн ангиллаар оруулаагүй нийт дүнгээр оруулж, хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.1.6, 6.3.1, 6.2.2, 6.2.3, 6.2.6, 6.3.3 заалтуудыг хэрэгжүүлээгүй байна.

Хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.7 дахь заалтын дагуу байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт хэсгийг 2017 онд 3-12 сард, 2019 оны 2, 7-р сард хугацаа хоцроож, орон тооны өөрчлөлтийн шалтгаан тайлбарыг оруулаагүй байна.

Гүйцэтгэлийн аудитын дүнгээр нийтдээ 97.0 сая төгрөгийн зөрчил илэрч зөрчил арилгуулах албан шаардлага өгөгдлөө.

БҮЛЭГ 2. ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЭРЭГЖИЛТ ҮР ДҮНТЭЙ БАЙНА.

2.1. Захиргааны хэргийн шийдвэр гүйцэтгэх үйл ажиллагааны хэрэгжилт үр дүнтэй байна.

2.1.1. Шийдвэр гүйцэтгэх үйл ажиллагааны бүртгэл, тайлагналыг зохих журмаар хийсэн байна.

Тус газар нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх үйл ажиллагааны бүртгэлийг сар бүр ШГ-1 маягтаар хөтөлж, сарын өссөн дүнгээр ШШГЕГ-т хүргүүлж ажилласан байна.

2017 оны 12 дугаар сарын мэдээгээр 42 хэргийн 1111.6 сая төгрөгийн гүйцэтгэх хуудасны үлдэгдэлтэй байснаа тайлант онд 3060.6 сая төгрөгийн гүйцэтгэх хуудас нэмэгдэж, 402.5 сая төгрөгийн гүйцэтгэх хуудас хасагдаж, гүйцэтгэвэл зохих 3769.8 сая төгрөгийн гүйцэтгэх хуудаснаас 1522.9 сая төгрөгийн хуудас гүйцэтгэж, эцсийн үлдэгдэл 2246.9 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна. Тайлант оны биелэлтийн хувь нь 40.3 хувьтай байна. Жилийн эцсийн үлдэгдэл хуудасны 31.1 сая төгрөгийн хуудас нь ял эдэлж байгаа, 2215.8 сая төгрөгийн хуудас нь бусад ангилалд бүртгэгдсэн байна.

2018 оны эхний үлдэгдэл 2246.9 сая төгрөгийн үлдэгдэлтэй байснаа 2557.8 сая төгрөгийн хуудас нэмэгдэж, 556.7 сая төгрөгийн хуудас хасагдаж, гүйцэтгэвэл зохих 4248.0 сая төгрөгийн гүйцэтгэх хуудаснаас 2239.2 сая төгрөгийн хуудас гүйцэтгэж, 2008.8 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарчээ. Биелэлт нь 52.7 хувьтай байна. Жилийн эцсийн үлдэгдэл хуудасны 2.3 сая төгрөгийн үлдэгдэл нь хорих ял эдэлж байгаатай, 2006.5 сая төгрөгийн үлдэгдэл бусад ангилал дээр байна.

2019 оны эхний үлдэгдэл 2008.8 сая төгрөгийн үлдэгдэлтэй байснаа 2464.9 сая төгрөгийн хуудас нэмэгдэж, 140.1 сая төгрөгийн хуудас хасагдаж, гүйцэтгэвэл зохих 4333.6 сая төгрөгийн гүйцэтгэх хуудаснаас 2040.8 сая төгрөгийн хуудас гүйцэтгэж, 2292.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна. Биелэлт нь 47.1 хувийн барагдалттай байна. Жилийн эцсийн үлдэгдэл хуудасны 1012.7 сая төгрөгийн үлдэгдэл бусад, 1280.1 сая төгрөг нь хэсэгчилсэн ангилалд бүртгэгдсэн байна.

Шийдвэр гүйцэтгэх үйл ажиллагааны бүртгэл тайлагналыг зохих журмаар хийж ажилласан байна.

2.1.2. Төрийн албанаас үндэслэлгүй халагдсан хүмүүсийн хохирлыг барагдуулах ажлын хэрэгжилт үр дүнтэй байна.

Аудитын явцад төрийн албанаас үндэслэлгүй халагдсан хүмүүсийн хохирлыг барагдуулсан талаарх судалгааг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газраас жил бүрээр гаргуулан авч, судалгааг анхан шатны баримттай нэг бүрчлэн тулгалт хийж, хохирлыг ямар эх үүсвэрээс барагдуулсан талаарх судалгааг 2017-2019 оны байдлаар нэгдсэн байдлаар гаргасан болно.

Үүнд 2017 онд 28, 2018 онд 62, 2019 онд 46, 2020 онд 24, нийт 160 хүнтэй холбоотой гүйцэтгэх баримтын хувийн хэргийг шалгаж, шүүхийн шийдвэрээс бусад

гүйцэтгэлтэй холбоотой нотлох баримтуудыг хуулбарлаж авч, ажлын баримт болгон бүрдүүлэлт хийлгэж авлаа.

Аймгийн Шүүхийн тамгын газарт дээрх хүмүүстэй холбоотой давхардсан тоогоор 160 хүний шүүхийн шийдвэрийн хуулбарыг авахаар тус газрын 2020 оны 11 дүгээр сарын 11-ны өдрийн 688 дугаар албан бичгийг хүргүүлэв.

Төрийн албанаас үндэслэлгүй халагдсан хүмүүсийн хохирлыг барагдуулсан байдлыг жил бүрээр авч үзвэл дараах байдалтай байна.Үүнд:

2017 онд 29 албан хаагчийн 16.1 сая төгрөгийн төлбөрийг барагдуулснаас 14.6 сая төгрөгийг төсөвт байгууллагаас, 1.5 сая төгрөгийг Хууль зүйн яамнаас төлсөн байна.

2018 онд 68 албан хаагчийн 185.1 сая төгрөгийн төлбөрийг барагдуулсны 102.0 сая төгрөгийг төсөвт байгууллагаас, 83.1 сая төгрөгийг Хууль зүйн яамнаас төлсөн.

2019 онд 46 албан хаагчийн 124.4 сая төгрөгийн төлбөрийг төсөвт байгууллагаас, 2020 онд 24 албан хаагчийн 120.4 сая төгрөгийн төлбөрийн 104.4 сая төгрөгийн төлбөрийг барагдуулсан.Үүнээс: 44.9 сая төгрөгийг төсөвт байгууллагаас, 59.5 сая төгрөгийг Хууль зүйн яамнаас тус тус төлж барагдуулсан судалгаатай байна.

2020 оны 9 дүгээр сарын байдлаар 2 албан хаагчийн 4.7 сая төгрөгийн хохирол барагдаагүй үлдэгдэлтэй байна.

Аудитын явцад 2017 оны 1 албан хаагчийн, 2018 оны 4 албан хаагчийн, 2019 оны 1 албан хаагчийн хувийн хэргийг архиваас олж өгч чадаагүй болно.

2.1.3. Шүүхийн шийдвэрийн төлбөрийн орлого, зарлагыг зохих журмаар бүртгэж, тайлагнасан байна.

Шүүхийн шийдвэрийн төлбөрийн орлого нь Төрийн банкны 291400002230 тоот дансаар 2017-2019 онуудад төлбөрийн орлого, хүүхдийн тэтгэмжийн орлого, урамшууллын орлого /2017 онд/, албадах ажиллагааны орлого, банкны хүүгийн орлого гэсэн нэр төрлөөс бүрдэж, орлогыг арилжааны банкны хуулгаар тооцоо нийлж газрын санхүүгийн программд оруулан бүртгэж, тооцоо хийсэн байна.

Тус газар нь 2017 онд төлбөрийн орлогоос 587.9 сая төгрөгийн, хүүхдийн тэтгэмжийн орлогоос 25.4 сая төгрөгийн, урамшууллын орлогоос 30.2 сая төгрөгийн, албадах ажиллагааны орлогоос 9.6 сая төгрөгийн, банкны хүүгийн орлогоос 1.2 сая төгрөгийн, нийт 654.3 сая төгрөгийн,

2018 онд төлбөрийн орлогоос 616.9 сая төгрөгийн, хүүхдийн тэтгэмжийн орлогоос 31.6 сая төгрөгийн, албадах ажиллагааны орлогоос 8.8 сая төгрөгийн, хүүгийн орлогоос 1.0 сая төгрөгийн, нийт 658.4 сая төгрөгийн,

2019 онд төлбөрийн орлогоос 838.4 сая төгрөгийн, хүүхдийн тэтгэмжийн орлогоос 49.5 сая төгрөгийн, албадах ажиллагааны орлогоос 11.9 сая төгрөгийн, хүүгийн орлогоос 0.8 сая төгрөгийн, нийт 900.6 сая төгрөгийн орлогыг тус тус төвлөрүүлсэн байна.

Хүснэгт №03

№	Орлогын төрөл	2017 он	2018 он	2019 он
1	Төлбөрийн орлого	587,852.1	616,975.6	838,371.9
2	Хүүхдийн тэтгэмжийн орлого	25,408.0	31,587.1	49,548.9
3	Урамшууллын орлого	30,191.2		
4	Албадах ажиллагааны орлого	9,624.3	8,792.9	11,882.0
5	Хүүгийн орлого	1,180.6	1,048.8	824.1
Нийт дүн		654,256.2	658,404.4	900,626.9

Эх сурвалж: ШШГГ-ын 2017-2019 оны Төрийн банкны хуулга, санхүүгийн баримт

Жил бүрийн орлогын хэмжээ нэмэгдэж байгаа нь шийдвэр гүйцэтгэх үйл ажиллагаа нэмэгдсэнтэй холбоотой байна. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зарцуулалтыг он оноор авч үзвэл:

2017 онд 569.6 сая төгрөгийг төлбөрийн зарлагад, 29.9 сая төгрөгийг хүүхдийн тэтгэмжид, 21.9 сая төгрөгийг урамшуулал цалинд, 2.4 сая төгрөгийг ажиллагаатай холбоотой урсгал зардалд /бичиг хэрэг, тээвэр шатахуун, дуудлага худалдаа, зар сурталчилгааны зардал/, 0.06 сая төгрөгийг банкны үйлчилгээний шимтгэлд, ШШГГ-т 26.5 сая төгрөгийг, нийт 650.4 сая төгрөгийн,

2018 онд 595.5 сая төгрөгийг төлбөрийн зарлагад, 42.2 сая төгрөгийг хүүхдийн тэтгэмжид, 12.0 сая төгрөгийг гүйцэтгэх ажиллагаатай холбоотой зардалд, 0.9 сая төгрөгийг банкны үйлчилгээний шимтгэлд, ШШГГ, хувь хүний зээлийн төлбөрт 11.5 сая төгрөгийг, 0.5 сая төгрөгийг хүүгийн орлогын төвлөрүүлэлтэд, нийт 662.7 сая төгрөгийн,

2019 онд 845.8 сая төгрөгийг төлбөрийн зарлагад, 47.6 сая төгрөгийг хүүхдийн тэтгэмжид, 15.8 сая төгрөгийг гүйцэтгэх ажиллагаатай холбоотой зардалд, 0.9 сая төгрөгийг банкны үйлчилгээний шимтгэлд, 0.3 сая төгрөгийг хүүгийн орлогын төвлөрүүлэлтэд, нийт 910.4 сая төгрөгийг тус тус зарлагдсан байна.

Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зардал жил бүр өссөн дүнтэй байна.

Хүснэгт №04

№	Зарлагын нэр төрөл	2017 он	2018 он	2019 он
1	Төлбөрийн зарлага	569,602.5	595,499.5	845,791.0
2	Хүүхдийн тэтгэмжийн зарлага	29,887.7	42,165.1	47,624.8
3	Урамшууллын зардал	21,943.2		
Гүйцэтгэл үйл ажиллагаатай холбоотой урсгал зардал				
1	Бичиг хэрэг	704.0	3,432.5	8,447.9
2	Шуудан холбоо			431.9
3	Тээвэр шатахуун	740.0	8,110.0	6,400.0
